



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 675

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн, аж ахуйг нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх" төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 16 нэрийн, нийт 795,526,400.00 (долоон зуун ерэн таван сая таван зуун хорин зургаан мянга дөрвөн зуу) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Өвөрхангай, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, "Үндэсний дата төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд тус тус бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, "Үндэсний дата төв" улсын төсөвт үйлдвэрийн захирал М.Баттулга, Өвөрхангай, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг бөлгөсугай

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
675 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ОРОН НУТГИЙН БОЛОН
ТӨРИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газарт бүртгэх хөрөнгө					
1	Хогны цэгийн мэдрэгч, Дата төлбөр /sensor/	200	ш	296,000	59,200,000.00
2	Шуурхай удирдлагын системийн тээврийн хэрэгслийн Хөдөлгөөн заагч /GPS/	20	ш	230,000	4,600,000.00
3	Тээврийн хэрэгслийн дугаар танигч төхөөрөмж /Камер, гэрэлтүүлэгч, Led дэлгэц/	2	ш	4,500,000	9,000,000.00
4	Тээврийн хэрэгслийн автомат хаалт	2	ш	2200000.00	4,400,000.00
5	Лазер мэдрэгч	2	ш	350000.00	700,000.00
6	Толгой компьютер	1	ш	1850000.00	1,850,000.00
7	Сүлжээний свич	1	ш	113200.00	113,200.00
8	Ухаалаг шон	3	ш	29,166,666.30	87,500,000.00
Хэсгийн дүн					167,363,200.00
Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгийн газарт бүртгэх хөрөнгө					
9	Тээврийн хэрэгслийн Хөдөлгөөн заагч /GPS/	20	ш	230,000	4,600,000.00
10	Тээврийн хэрэгслийн дугаар танигч камер	2	ш	4,500,000	9,000,000.00
11	Тээврийн хэрэгслийн автомат хаалт	2	ш	2,200,000	4,400,000.00
12	Лазер мэдрэгч	2	ш	350,000	700,000.00
13	Толгой компьютер	1	ш	1,850,000	1,850,000.00

Д/д	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
14	Сүлжээний свич	1	ш	113,200	113,200.00
15	Ухаалаг шон	3	ш	29,166,666.60	87,500,000.00
Хэсгийн дүн					108,163,200.00
"Үндэсний дата төв" улсын төсөвт үйлдвэрийн газарт бүртгэх хөрөнгө					
16	Суурь дэд бүтэц (клауд лиценз)	40	ш	13,000,000	520,000,000.00
Хэсгийн дүн					520,000,000.00
Нийт дүн					795,526,400.00 (долоон зуун ерэн таван сая таван зуун хорин зургаан мянга дөрвөн зуу)

